

MEMORANDUM OF UNDERSTANDING

22 December 2024

Sydney

The Australian Dispute Resolution Association (hereinafter also referred to as the "ADRA"), represented by Co-Presidents, Katherine Pavlidis Johnson and Geoffrey William Charlton, on the one hand and the Judicial General Council of Mongolia (hereinafter referred to as "JGC"), represented by Chair Enkhbileg Lkhagvadorj on the other hand, together hereinafter referred to as the "Parties" and individually a "Party", have concluded this Memorandum of Understanding.

1. Status of the Memorandum of understanding

- 1.1. Parties mutually agree to develop and implement modern approaches of court mediation/dispute resolution to the Mongolian judiciary and justice sector through the support of the ADRA.
- 1.2. Parties mutually acknowledge to organize and carry out training activities in both in-class and electronically by Zoom, Teams or other visual communication system.

2. General Provisions

- 2.1. The purpose of cooperation between the Parties is to establish partnership to develop and implement modern approaches of court mediation/dispute resolution to the Mongolian judiciary and justice sector and implement best practices.
- 2.2. Parties hereby agree to implement and arrange training activities for court mediators of Mongolian judiciary one to two times a year.
- 2.3. Parties hereby agree to hold online training, webinar, or inviting relevant professionals and officials in the field of court mediation/dispute resolution for capacity building of Mongolian court mediators.
- 2.4. The training to be arranged by ADRA is subject to ADRA obtaining the involvement of experienced mediators from among its members or otherwise.

3. Implementation of cooperation

- 3.1. The parties agree to collaborate on scheduling and arranging of training/study program for the trainings contemplated.
- 3.2. The sender Party shall cover and bear all related costs for roundtrip flight and visa application. Accommodation, meal and transportation are as mutually agreed between the Parties at the time the trip was agreed.


4. The validity of the Memorandum of Understanding

- 4.1. This Memorandum of Understanding shall enter into force upon signing by the Parties.
- 4.2. This Memorandum of Understanding is concluded for a 5 (five) year term since entering into force and can be renewed on mutual agreement. Upon official intent to terminate by either party, the MoU will be subjected to be terminated at the same time.

5. Other

- 5.1. Any amendments to this MoU shall be made in writing upon agreement of both Parties.
- 5.2. All questions or disputes between the Parties concerning the implementation of this MoU shall be settled by consultation and negotiation between them.
- 5.3. This MoU is drawn up two copies in English and Mongolian languages. In the event of disagreement as to the interpretation of this MoU, the English version will prevail.

6. The signature of the Parties



KATHERINE PAVLIDIS JOHNSON
GEOFFREY WILLIAM CHARLTON

Co-Presidents of Australian Dispute
Resolution Association

Address: PO Box A2468 Sydney South
NSW 1235 ABN 75 535 099 840



ENKHBILEG LKHAGVADORJ

Chair of the Judicial General Council of
Mongolia

Address: Tasganii ovoo, Chingeltei district,
5 khoroo, Ulaanbaatar-15170, Mongolia



ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

2024 оны 12 дугаар сарын 22

Сидней хот

Энэхүү Харилцан ойлголцлын Санамж бичгийг (цаашид “Санамж бичиг” гэх) нэг талаас Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид “ШЕЗ” гэх), түүнийг төлөөлж дарга Лхагвадоржийн Энхбилэг, нөгөө талаас Австралийн Холбооны Улсын “Австралийн маргаан шийдвэрлэх холбоо” (цаашид “АМШХ” гэх), түүнийг төлөөлж Ерөнхийлөгч Катерин Павлидис Жонсон, Жеоффри Виллъям Чарлтон (цаашид хамтад нь “Талууд” гэх бөгөөд аль нэг талыг “Тал” гэх) нар байгуулав.

1. Санамж бичгийн нөхцөл

- 1.1. Талууд Монгол Улсын шүүх засаглал болон хууль, эрх зүйн салбар дахь шүүхийн эвлэрүүлэн зуучлал/маргаан шийдвэрлэлтийн орчин үеийн арга барилыг АМШХ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж, хөгжүүлэхээр харилцан тохиролцов.
- 1.2. Талууд танхимын болон Zoom, Teams зэрэг дүрс харилцаа холбооны систем ашиглан цахимаар зайн сургалтын үйл ажиллагааг хамтран зохион байгуулж явуулахыг харилцан хүлээн зөвшөөрөв.

2. Ерөнхий зүйл

- 2.1. Талууд хоорондын хамтын ажиллагааны зорилго нь Монгол Улсын шүүх засаглал болон хууль, эрх зүйн салбар дахь шүүхийн эвлэрүүлэн зуучлал/маргаан шийдвэрлэлтийн орчин үеийн арга барилыг хэрэгжүүлж хөгжүүлэхтэй холбогдуулан хамтын ажиллагаа, түншлэлийг тогтооход оршино.
- 2.2. Талууд Монгол Улсын шүүхийн эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан сургалтын үйл ажиллагааг жилд нэгээс хоёр удаа зохион байгуулахаар харилцан тохиролцов.
- 2.3. Талууд Монгол Улсын шүүхийн эвлэрүүлэн зуучлагчдыг чадавхжуулах үүднээс мэргэжилтэн, зөвлөхүүдийг урих, мөн цахим сургалт, сөмнар хамтран зохион байгуулахыг үүгээр харилцан хүлээн зөвшөөрөв.
- 2.4. АМШХ-оос зохион байгуулж буй сургалтуудад АМШХ өөрсдийн гишүүдээс туршлага бүхий эвлэрүүлэн зуучлагч нар болон бусад мэргэжилтнүүдээс оролцуулах асуудлыг шийдвэрлэнэ.

3. Хамтын ажиллагааны хэрэгжилт

- 3.1 Талууд сургалт/танилцах, туршлага судлах хөтөлбөрийг төлөвлөж, зохион байгуулахаар хамтран ажиллахаар харилцан зөвшөөрөв.
- 3.2 Илгээгч тал 2 талын нислэг, виз авахтай холбоотой зардлыг хариуцна. Байр, хоол, хот доторх унааны зардлыг тухайн танилцах аялал, арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэсэн тухай бүрд Талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

4. Харилцан ойлголцлын санамж бичгийн хүчинтэй хугацаа

- 4.1. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
- 4.2. Санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 /таван/ жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Талуудын зөвшилцлөөр хугацааг сунгаж болно. Санамж бичгийг цуцлах тухай аль нэг тал нөгөө талдаа мэдэгдсэн бол тэрхүү мэдэгдсэн үеэс санамж бичгийг цуцлагдсанд тооцно.

5. Бусад

- 5.1. Талууд бичгээр харилцан тохиролцсоны дагуу харилцан ойлголцлын санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ нь санамж бичгийн салшгүй нэг хэсэг байна.
- 5.2. Харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан маргааныг талууд харилцан тохиролцож зөвшилцсөний үр дүнд шийдвэрлэнэ.
- 5.3. Энэхүү Санамж бичгийг Монгол, Англи хэл дээр тус бүр хоёр хувь үйлдэв. Санамж бичгийг тайлбарлахад зөрүүтэй байдал үүсвэл англи хэл дээрх эхийг баримтална.


7. Талуудын гарын үсэг, тамга



ЛХАГВАДОРЖИЙН ЭНХБИЛЭГ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга

Хаяг: Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр, Тасганы овоо, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Улаанбаатар 15170, Монгол Улс



КАТЕРИН ПАВЛИДИС ЖОНСОН
ЖЕОФФРИ ВИЛЛЪЯМ ЧАРЛТОН

Австралийн маргаан шийдвэрлэх
холбооны Ерөнхийлөгч

Хаяг: Сидней, Өмнөд NSW 1235 ABN
75 535 099 840, ШХ А2468, Австралийн
Холбооны Улс